



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023. 06. 26 № 01/966

танай _____ -ны № _____ -т

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН
ГЭГЭЭРҮҮЛЭХ ХЭЛТЭСТ**

Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын
авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны эхний
хагас жилийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ
хийлгүүлж хүргүүлэв.

Хавсралт:хуудас

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4803140610

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТТЭЛИЙН ТАЙЛАН

2023.06.22

Д/д	Зорилт, арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
1.1	<p>Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх.</p>		Түгээсэн тоо (Баримтжуулсан байх)	19	19	<p>Авлигын цаана, Авлига-хожихгүй нүүдэл, Авлигын эсрэг олуулаа нэгдье, Шударга үнэний үнэ цэнэ, Гэрэл тусгая, Чи бол Авлигатай тэмцэх газар, Авлигын шилэн бөмбөлөг, Ээжийн захиа, Авлига нь үр хүүхдүүдийн маань гэрэлт ирээдүйг хулгайлдаг, Авлигатай тэмцэх нь бүх нийтийн үйлс Та яг одоо 110 руу залгаарай, Шударга тоглоцгооё видео шторк, Тангараг, АТГ граж, Үр, Аавын захиас, Авлигын цаас, Хахуул, 110 утас, Ээжийн захиа шторк контентууд, Нэгдье постер, шторкуудыг Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайт, аймгийн ИТХ-ын цахим хуудас www.khural.mn, ГХУСАЗСЗ-ийн пэйж хуудас, Дундговь аймгийн ЗДТТ, "Дундговь Эрх зүйн хөтөч" пэйж хуудсууд болон сум, байгууллагуудын сайт, бусад пэйж хуудсуудаар; сум, байгууллагуудын үүдний хэсэгт байрладаг "Цахим мэдээллийн дэлгэц" зэргээр төрийн албан хаагч болон иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.</p>	100
		Давтамж (Баримтжуулсан байх)	2	2	6	<p>Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 6 төрлийн тараах материал болох 110 дугаарын сурталчилгаа, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, Авлигын хэлбэрүүд, Авлигын тухай мэдэгдэх сурталчилгаа, АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар, Авлигагүй Дундговь пэйж хуудсуудад нэгдэх сумдын Засаг даргын</p>	

							Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг болон иргэд, олон нийтэд 300 ширхэгийг өнгөтөөр хэвлэн олшруулан хүргүүлж, цаашид сум, байгууллагуудыг олшруулан иргэд, албан хаагчдад түгээхийг аймгийн Засаг даргаас үүрэг болгон албан бичгээр хүргүүлсэн. Сум бүрт видео контент, шторк, CD зэргийг тусгайлан хүргүүлж, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.	
					Авсан хандалтын тоо (Баримтжуулсан байх)	250	300	Постер, шторкийг аймаг, сум, байгууллагуудын сайт, пэйж хуудсуудаар сурталчилж 511 хандалт авсан.
1.2	Авлигын нөлөөллийн хэмжээг дэвсгэрийн байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	эсрэг арга нутаг нэгж, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах.	2.0 сая.төг	Өдөрлөг, нөлөөллийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан тоо (Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргах)	2	2	Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил"-ийг дэмжин "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд Авлигатай тэмцэх газраас авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан "Нэгдье" аяныг эхлүүлэн аймгаас гарах зам болон төвийн дөрвөн замын уулзварт "НЭГДЬЕ" 2 ширхэг постерыг байршуулан, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, албан хаагчдыг манлайлан оролцохыг аймгийн Засаг даргаас үүрэг болгон хамтран ажиллах албан бичгийг хүргүүлээ.	100
1.3	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах.	эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах.	250.000	Мэдээллийг сар бүр шинэчилж байршуулсан тоо	12	12	Аймаг, сумын ЗДТГ, хэлтэс, агентлагийн албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой "Шударга ёс, хөгжил дэвшилд-110" самбар ажиллуулах, өрөө, танхимын хаалганд "Тат, түлх" хэлбэрээр авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан стикерийг байршуулах, төрийн албан хаагчдын компьютерт 110 дугаарыг	100

						сурталчилсан наалт наах, иргэд, олон нийтэд 110 дугаарын сурталчилгааг олшруулан тараах, аймгийн ЗДТГ-ын Олон нийттэй харилцах үүдэн хэсэгт "Дундговь авлигагүй хөгжинө", "110 дугаарын сурталчилгаа"-ны зурагт баннер зэргийг байнга байршуулан сурталчилж хэвшүүлсэн. Уг самбаруудад 110, нэгдье постеруудаар мэдээллийг шинэчилэн байршуулсан.					
					Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх	12	12	12			Сум, байгууллагууд "Шударга ёс-хөгжил дэвшилд-110" самбарын мэдээллийг сар бүр шинэчлэн байршуулж байна.
					Хоёроос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх	2	2	2			Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан зорилгоор өөрсдийн бүтээл болох Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газраас бэлтгэсэн нөлөөллийн харандааны адал явдал, 2D animation ургэлжлүүлэн сурталчиллаа.
1.4	Өөрсдийн ажиллагааг эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонин нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх.				Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсанд байршуулах /Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх/	2	2	2			Тус аймгийн www.duldovi.gov.mn сайтаар авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх 110 дугаар, авлигын эсрэг Нэгдье шторк, постерийг байнга байршуулан сурталчиллаа.
Хоёр. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах											
2.1	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх.	-			Шинээр томилогдсон албан хаагчийг сургалтад хамруулсан тоо	45	55	100			Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлигын эсрэг сургалтанд төрийн албан хаагчдыг оролцуулах ажлыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулж, хэлтэс агентлагийн дарга, төрийн захиргааны болон

						терийн үйлчилгээний 315 албан хаагчид хамрагдаж, үүнээс төрийн албанд шинээр томилогдсон 56 албан хаагчийг оролцууллаа.	
2.2	Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-	Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах (Тайланд нотломжийг хавсаргах)	1	1	Худалдаа үйлчилгээ хариуцсан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний танхимуудад "авлигын эсрэг нэгдье" постеруудыг А4 хэмжээгээр байршуулан сурталчиллаа. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн судалгааг https://dundgov.gov.mn/ сайтад мэдээлж ил тод байдлыг ханган ажилласан	70
Гурав. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох							
3.1	Төрийн хувийн хооронд аливаа хэлэлцээрт урьдчилан байгууллага, хэвшлийн байгуулах гэрээ авлигаас хэлэлцээрт авлигаас сэргийлэх	Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан эсэх (Тийм-1, үгүй-0)		1	1	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулж буй аливаа гэрээ хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгах саналын төслийг боловсруулан, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт аймаг,	100

<p>асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.</p>		<p>Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх (тийм-1, үгүй-0)</p> <p>Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)</p>	<p>1</p>	<p>1</p>	<p>сумын Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагуудад 2 талын хүлээх үүргийг хургуулсэн.</p> <p>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулж буй гэрээнд гэрээ байгуулах үед авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах, илт ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөлд албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх зэрэг талуудын 11 үүргийг тусгаж өгсөн.</p>	
<p>“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх</p>		<p>Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх (тийм-1, үгүй-0)</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>Уг журмын дагуу хамтран ажиллах гэрээний дагуу 4 сайт, 3 ТВ, 2 сонин нийт хэвлэл мэдээллийн 9 байгууллагын мэдээллийн хэрэгслээр дамжуулан онцлох ажлын мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 21 мэдээллийг гэрээт ТВ, сайт, сонины газарт хүргүүллээ.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт улирлаар гарч байгаа бөгөөд 1 дүгээр улирлын байдлаар цахим системд нийт 6700 мэдээлэл оруулахаас 6415 мэдээлэл оруулсан үүнээс 6218 нь хугацаандаа оруулсан мэдээний гүйцэтгэл 95.7 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулан төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг ил тод нээлттэй байршуулан ажиллаж байна.</p> <p>Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Татварын хэлтэс, Сайнцагаан сумын 6, 7 дугаар цэцэрлэг, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Өндөршил,</p>	<p>70</p>
<p>3.2</p>		<p>Сургалт, мэдээлэл авсан тоо</p>	<p>-</p>	<p>1</p>		

	<p>Гурвансайхан сумдын иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл, төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр 7 удаагийн эрх зүйн сургалтуудыг Эрх бүхий албан тушаалтан өөрийн нөөц бололцоогоор зохион байгууллаа.</p> <p>Албаны эрх мэдлээ хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаандаа төрийн албанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн Гурвансайхан, Баянжаргалан сумын Засаг дарга нарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.</p> <p>Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>				
<p>4.1</p> <p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил байдлыг гомдол нэмэгдүүлэх, мэдээлэлд шинжилгээ асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)</p>	<p>Дөрөв. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p> <p>Аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээ хариуцсан хэлтсийг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тус хэлтсийг ажиллах нөхцөл боломжоор бүрэн ханган ажиллаж байна. Мөн аймгийн төвд төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” гурван цэгийг шинээр байгуулж, орон нутгийн хөрөнгөөр 30 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл, тавилга тоног төхөөрөмжөөр хангаж, 440 төрлийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.</p> <p>Албан бичиг солилцооны дундын системд холбогдох талаар цахим сургалтыг сум, байгууллагын удирдлага, албан хэрэг хөтөлтийн ажилтнуудад нийт 90 гаруй төрийн албан хаагчдад зохион байгуулж, цахим гарын авлагаар хангасан. 2023 оны эхний хагас</p>	<p>Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)</p>	<p>1</p>	<p>1</p>	<p>100</p>

	<p>жилийн байдлаар 15 сумдын Засаг даргын Тамгын газар албан бичиг солилцооны дундын системд холбогдож, ашиглаж байгаа цахим системээс үл хамааран бүх төрийн байгууллагуудад албан бичиг цахимаар илгээж байна</p> <p>Албан бичиг боловсруулалтыг цахимд шилжүүлэх, байгууллага хооронд тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан бичиг илгээх зорилгоор тоон гарын үсэг гэрчилгээжүүлэгч "Тридум секорити" компанитай гэрээ байгуулан аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын удирдлагуудад албан тушаалын тоон гарын үсэгтэй ажлын зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын 8, 15 сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар 30, агентлагууд 10, төрийн цахим үйлчилгээний хэлтэс, операторууд 19 нийт 72 албан тушаалтнууд албан тушаалын тоон гарын үсэгтэй болж албан бичиг цахимаар боловсруулах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>7059106 утсанд иргэдээс 24 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс 6 өргөдөл судлагдаж байгаа бөгөөд 18 өргөдөл хугацаандаа шийдвэрлэгдсэн. Нийт 151 өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч хэрэгжилт 90,5 хувьтай шийдвэрлэгдэж хэрэгжсэн.</p>	<p>Эхний хагас жилийн байдлаар хөтөлбөрийн дагуу 14 суманд "Иргэдээ сонсье" уулзалт хэлэлцүүлэг, аймгийн төвийн Сайнцагаан суманд эмэгтэйчүүд, хүүхэд, эрэгтэйчүүдийн 4 удаагийн нийт 18 удаагийн уулзалт зохион байгуулж, уг уулзалт, хэлэлцүүлэгт 2492</p>
		<p>2</p>
		<p>-</p>
		<p>1</p>
		<p>2</p>
		<p>100</p>

	уулзалт байгуулж, нөхцөлийг арилгасан байх.	хэмжээ зохион байгуулсан байх(Тайланд нотломжийг хавсаргасан байх)			иргэн оролцсон. Зүүн сумдад зохион байгуулсан эхний "Иргэдээ сонсье" уулзалт, хэлэлцүүлгээс гарсан санал хүсэлтийн 70 хувийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.	30
4.3	Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Бодитой үр дүнг тооцсон байх(Тайланд нотломжийг хавсаргасан байх)	-	1	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох судалгаанд өмнөх онд 220 иргэнээс тус судалгааг авахад үнэлгээний хувь 50 хувьтай байсан бол тайлант хугацаанд 270 иргэнийг судалгаанд хамруулж, иргэдийн сэтгэл ханамж 62,4 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.	30
Тав. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.						
5.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэлтэс, агентлаг, хүрсэн үр дүнг жилийн эцэст нийт албан хаагчдад танилцуулах.	Төлөвлөгөөг баталж, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн загварын дагуу 5 зорилт, 21 арга хэмжээтэй төлөвлөж, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх 5 дугаар зорилтын хүрээнд аймгийн удирдлагаас санаачлах үйл ажиллагаануудыг боловсруулан аймгийн Засаг даргаар 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдөр батлуулан хэрэгжилт 89.5 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж байна.	100
	Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)		-	1	Төрийн албан хаагчдад шударга ёсыг төлөвшүүлэх зорилготой "Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа" аяныг жилийн туршид Засаг даргын дэргэдэх хэлтэс агентлаг, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдээр аялуулж, шударга ёсыг төлөвшүүлэх, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаар, авлигын эсрэг Нэгдье	


	уриалгыг сурталчлан таниулах ажлыг тус тус зохион байгууллаа.				
5.2	<p>Авлигатай тэмцэх газрын мөрдөгч О.Нармандахын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр мөрдөгчийн мэдэгдлийн дагуу Гурвансайхан, Өндөршил сумдын төрийн албан хаагчдад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг болох Авлигын гэмт хэргийн Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах зэрэг хууль тогтоомжуудаар сургалт, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх талаар ярилцлага зохион байгуулав.</p> <p>Мөн 15 сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, мэргэжилтнүүдэд байгаль орчны эсрэг зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Уул уурхайн нөхөн сэргээлт, хууль, эрх зүйн орчин", "Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд анхаарах асуудлууд", "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын талаар чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулав.</p>	1	1	<p>Мөрдөгчийн мэдэгдэл, зөвлөмж, саналыг хэрэгжүүлсэн байх</p> <p>(Тайланд нотломжийг хавсаргасан байх)</p>	100
5.3	<p>Шийдвэр гаргах эрх бүхий тушаалтнууд НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 17 дугаар</p>	0	1	<p>-Ойн арга хэмжээтэй сум, байгууллагуудын судалгааг гаргаж,</p>	70


	зүйлд заагдсан хандив тусламжтай холбоотой хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах.		урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байх (тийм-1, үгүй-0)			сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заагдсан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.	
5.4	Төрийн албан хаагчдад шударга ёсыг төлөвшүүлэх зорилготой "Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа" аяныг хамтдаа" аяныг зохион байгуулах.		Khutibayr.iass.mn цахим санд тайлагнасан байх	1	1	Төрийн албан хаагчдад шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой тус хугацаанд "Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа" аяныг Засаг даргын дэргэдэх хэлтэс агентлаг, Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгүүдээр аялуулж, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх 110 дугаарыг сурталчлан таниулах үйл ажиллагаануудыг идэвхжүүлэн аянд 25 байгууллагыг одоогоор нэгдүүлэн www.dundgov.gov.mn сайтад байршуулан сурталчилж ажиллалаа.	100
5.5	Иргэдэд чирэгдэл учруулж буй орон сууцны дулааны асуудлыг шийдвэрлэх.		Олон нийтийг дулаанаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх (тийм-1, үгүй-0)	0	1	"Тэвшийн говь" ХХК-ийн халаалтын үйл ажиллагаа доголдож эрсдэлтэй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/40 дүгээр шийдвэрээр ажлын хэсэг байгуулан 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс "Дундговь-Ус" ОНӨААТҮГ-т шилжүүлэн авч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг халаалт, дулаанаар хэвийн хангаж ажиллуулсан үр дүн гарсан.	100
5.6	5.6. АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг албан хаагчдаар дагуулах ажлыг зохион байгуулах.		Аян, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаанд тус пейжийг сурталчилж, иргэд, төрийн албан хаагчдаар дагуулж, үр дүнг	0	1	Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа аянаар АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар, Авлигагүй Дундговь пэйж хуудсуудад төрийн албан хаагч бүрийг нэгдүүлж, нэг төрийн албан хаагч нэг иргэнийг дагагчаар нэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд аймгийн хэмжээнд нийтдээ 6675 хүн пэйж хуудсуудад нэгдсэн судалгаатай болсон.	100


	<p>Төрийн байгууллагуудын удирдах тушаалтнуудын албан гаргасан шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	<p>Тооцсон байх (Тийм-1, Угүй-0)</p> <p>Хагас бүтэн жилээр хяналтыг хэрэгжүүлж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байх</p>	
5.7	<p>Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 290 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд тушаал боловсруулсан алба хаагч хяналтын дагалдах хуудсыг хэлтсийн дарга нараар хянуулан санал авах ажлыг зохион байгуулсан. Тус оны эхний хагас жилийн байдлаар батлан гаргасан 325 захирамжийн 86.7 хувь нь хяналтын дагалдах хуудсаар хянагдсан. Сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагаас батлан гаргасан 1079 эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянахад 84.99 хувь нь хууль тогтоомжид нийцэж байсан ба зөрчилтэй 162 захирамж, тушаал буюу 15.01 хувийг хууль тогтоомжид нийцүүлэн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.</p>	<p>0</p> <p>1</p>	<p>100</p>
5.8	<p>Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ангийн хүүхдүүдийн ахлах дунд "Шударга хүүхэд" сэдвээр ярилцлага зохион байгуулах.</p>	<p>Ярилцлага зохион байгуулсан байх (Тийм-1, Угүй-0)</p>	<p>1</p> <p>1</p>
	<p>Дэлгэрхангай, Гурвансайхан, Сайнцагаан сумын Мандал, Хүмүүнлэг, Эрдмийн далай цогцолбор сургуулийн ахлах ангийн 480 сурагчдыг оролцуулан "Шударга хүүхэд" сэдвээр ярилцлагыг зохион байгуулж ажиллалаа.</p>		<p>70</p>

	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилттэй зогсонги байдалд орсон, гэрээт ажлаа гүйцэтгээгүй ажлуудын гүйцэтгэгч компани, аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээний үүргийн биелэлтийг тооцох арга хэмжээг зохион байгуулах.	-	Дүн шинжилгээ хийсэн байх, (тийм-1, үгүй-0) Гэрээний үүргийн биелэлтийг тооцож, шаардлагатай тохиолдолд тендэрт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх (тийм-1, үгүй-0)	0	1	2021 онд Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн ажлын гүйцэтгэгч Ээбо порпортийз ХХК нь ковид цар тахлын улмаас ажил зогссон гэх үндэслэлээр тус оныг хүртэл ажлаа үргэлжлүүлээгүй, 68 хувийн гүйцэтгэлтэй 2 жил дамжсан тул гэрээг цуцалж захирамжийг хүргүүлээд байна.	100
5.9		-		0	1		
	МУЗГ-ын 49 дүгээр тогтоолоор батлагдсан "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон" зарласан таван "Ш" ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5	Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх чиглэлээр 5Ш ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулж буй "Шүүр" ажиллагааг Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2023 оны ХЭГ/595 дугаартай "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2023.03.28-ны өдрийн А/160 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж ажлын хэсэг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 23 хэлтэс, агентлаг, орон нутгийн өмчит газар, улсын төсвийн 12 байгууллага, 15 сумын 97 төсвийн байгууллагуудад 2023.03.29-2023.04.06-ны өдрүүдэд 11 чиглэлийн дагуу шүүр ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.	70
5.10		-		-			

<p>Хяналт шалгалтаар 11 чиглэлийн дагуу 132 байгууллагын 3270 төрийн албан хаагчийн материалыг хянан үзэж 147 зөрчлийг илрүүлэн МУ-ын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>“Шил ажиллагаа”-ны хүрээнд тус онд аймгийн нэгдсэн сайтыг шинэчлэн, нээлттэй мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласнаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 7 хоног бүр хийгдэж буй үнэлгээгээр 88.88 хувьтай үнэлэгдсэн үр дүн гарсан.</p>							<p>Нийт дүн</p>	<p>89.5</p>
---	--	--	--	--	--	--	-----------------	-------------

ТАЙЛАНГ ҮНЭЛСЭН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  (П. ДОРЖБАТ)

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 ХЭЛТСИЙН ДАРГА  (ДААРЙЙМАА)

ТАЙЛАГНАСАН:
 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
 ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  (С.ЦЭНГЭЛМАА)